



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1996 оны 01 дугаар
сарын 10 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар
хот

Малын зах ажиллуулах
тухай

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, "Нирун" ХХК-ний саналыг үндэслэн малын "Хуаран" захыг Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт нээн ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
2. Нийслэлийн малын захад худалдаа үйлчилгээ явуулах журам", Нийслэлийн Засаг даргын 1993 оны А-231 тоот захирамжийн дагуу зохион байгуулж ажиллуулахыг "Нирун" ХХК \Б.Жаргалсайхан\ -д үүрэг болгосугай.
3. Тус захын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, дэг журам зохион байгуулалт, ариун цэврийн шаардлага хангуулж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг дарга \Г.Цэрэнбаатар\ -т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БЭГДЭД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.Баасанжав

Ц. БААСАНЖАВ